

Эм уух зөвлөмж

#2

MEDWAVE

5 ЗӨВИЙН ЗАРЧИМ

ЗӨВ



ЭМИЙГ

ЗӨВ



ХҮНД

ЗӨВ



ТУНГААР

ЗӨВ



ЦАГТ

ЗӨВ



АРГААР

ӨГӨХ



Аливаа өвчин эмгэгийн үед хэрэглэж буй эм тариаг 5 зөвийн зарчмыг баримтлан хэрэглэвэл зохистой билээ.

- Шаардлагагүй эм тариаг дур мэдэн хэрэглэх,
- Тухайн хүнд хэрэглэж болохгүй эм тариаг хэрэглэх, Тухайн хүнд таарахгүй тунгаар хэрэглэх,
- Тохиромжгүй цагт хэрэглэх,
- Буруу аргаар хэрэглэх зэрэг нь эм тарианы үр нөлөөг бууруулж, цаашлаад сөрөг үр нөлөө гарах эрсдэлтэй байдаг.

Манайхан энэ эмийг би уугаад зүгээр болсон энийг уучих, энэ их сайн эм гээд ам дамжсан яриагаар бие биендээ эм зөвлөх нь элбэг. Гэтэл тухайн хүн ахин давтагдашгүй өөр тул таны танилд таарсан эм танд таарахгүй байх боломжтой.

Эмийг хэрхэн зөв хадгалах вэ?

- Гэрийн нөхцөлд эмийг зөв хадгалах нь эмчилгээний үр дүнд ихээхэн нөлөөлдөг.
- Ямар ч эмийг хүүхэд хүрэхээргүй газарт хадгалах
- Эмийн санд найруулсан уусмал эмийг 4 хоногоос илүү хугацаагаар хадгалаж болохгүй.
- Хэт дулаан, гэрлийн шууд тусгалаас хамгаалах нь чухал. Ялангуяа гал тогооны өрөө, угаалгын өрөө, цонхны тавиур дээр эмийг бүү хадгал. Чийг, дулаан нь эмийн чанарыг алдагдуулдаг.
- Шингэн эмийг хөлдөхөөргүй хадгалах.
- Нэр, тун, хэмжээ, хадгалах хугацаа нь тодорхойгүй буюу хугацаа нь дууссан эмийг бүү хадгал.

Эмийг хэзээ, яаж хэрэглэх вэ?

Зайлшгүй эм хэрэглэх болсон үед эмэн бус эмчилгээгээр эмчлэх боломжгүй буюу тусламж шаардлагатай үед эмчийн заавраар хэрэглэнэ. Харин эмийг өдөрт хэдэн удаа, яаж хэрэглэхийг эмчээс асууж, эмийн сангаас авч хэрэглэх нь зүйтэй. Ихэнх эмч ходоодны хүчлийн нөлөөгөөр идэвхи нь сулардаг тул эмийг хоолны дараа уух хэрэгтэй.

Хоолны өмнө хэрэглэх эмийг хооллохоос 20-30 минутын өмнө ууж хэрэглэх нь тохиромжтой. Ихэнх эмийг буцалсан усаар даруулж уудаг. Эм уух хоорондын зай 15-20 минут .